

СОЛОНГОС ХЭЛНИЙ КАССЕН КЛУБИЙН

2019-2022 ОНЫ ТАЙЛАН

Тус клуб нь 2019 оны 9 сарын 15-нд ШУТИС-ийн ГХС-ийн Гадаад хэлний орчуулга /солонгос хэл/ хөтөлбөрөөр сурч буй оюутнууд, солонгос хэлний багш нарын санаачлагаар ГХС-ийн 25 оюутан, 1 багшийн бүрэлдэхүүнтэй байгуулагдав.

Солонгос хэлний клубийн зөвлөх багшаар солонгос хэлний багш Т.Мөнхжаргал, клубийн ахлагчаар ГХС-ийн 2-р курсийн оюутан О.Хүслэн нар ажиллаж эхэлсэн юм. Солонгос хэлний клубийн гишүүд солонгос хэлний мэдлэгээ бие биетэйгээ хуваалцах, солонгосын соёлоос хамтран суралцах, анхан шатны суралцагсад солонгос хэл заах, өөрсдийн сурах арга барилаа сайжруулахын төлөө ажилладаг билээ. Клубийн үйл ажиллагаанд солонгос хэлний ангийн оюутнуудаас гадна ШУТИС-ийн бусад ангийн оюутнууд элсэн орж солонгос хэл сурч, соёлын арга хэмжээнд оролцдог. Тус клубийн гишүүд солонгосоор ярих ур чадвараа сайжруулах зорилгоор солонгос багш, оюутантай ярианы дадлага хийх төдийгүй сайн дурын үйл ажиллагаанд ч идэвхитэй оролцдог юм.

Солонгос хэлний клубийн зохион байгуулсан ажлууд

Төгсөгч Б.Болорчимэг, М.Мөнхзул нартай хийсэн уулзалт 2019



2012 оны төгсөгч Б.Болорчимэг, 2013 оны төгсөгч М.Мөнхзул нартай хийсэн уулзалтаар хичээл сурлагадаа шамдаж сурахын ач холбогдол, суралцах явцдаа болон дараа нь санаж явбал зохих сургамжтай зүйлсийн талаар ярилцлаа. М.Мөнхзул оюутан байх хугацаандаа хичээнгүй сурч, төгсөхөөсөө өмнө ТОПИК шалгалтын 6-р түвшинд тэнцэж байсан тухайгаа яриад оюутан дүү нартаа хичээнгүй суралцахыг уриалж байлаа. БНСУ-д магистрын зэргээ хамгаалаад докторантаар элсэн суралцаж байгаа Б.Болорчимэг БНСУ-д дараачийн шатлалын сургуульд суралцахын тулд хэрхэн бэлдэх, гадаадад сурахын давуу болон сул талын талаар ярьсан юм.

Төгсөгч Б.Золзаяа, Б.Ариунжаргал нартай хийсэн уулзалт 2019



2010 оны төгсөгч Б.Золзаяа, 2011 оны төгсөгч Б.Ариунжаргал нарын хувьд төгссөнөөс хойш солонгос хэлний мэргэжлээ ажилдаа бүрэн ашиглаж байгаа тул хэл сайн сурахын давуу талыг тайлбарлан ярилаа. Б.Золзаяа Грандмед эмнэлгийн гадаад харилцаанд нэлээд хэдэн жил ажиллаж БНСУ, Монголын харилцаанд хувь нэмрээ оруулж байгаа тухайгаа, Б.Ариунжаргал БНСУ руу эмнэлгийн аялал жуулчлалаар монгол жуулчдыг аялуулдаг, мөн солонгос жуулчдыг эх орондоо хүлээн авдаг ялал жуулчлалын компаниа байгуулан ажиллаж байгаа тухайгаа сонирхолтой яриа өрнүүлсэн юм.

Төгсөгч Мөнхтулга, Баярхүү нартай хийсэн уулзалт 2020




2014 оны төгсөгч Баярхүү, 2015 оны төгсөгч Мөнхтулга нартай хийсэн уулзалт энгийн, дотно яриа болж өрнөсөн юм. Төгсөгч Баярхүү уул уурхайн салбарт орчуулагчийн ажил хийхийн бэрхшээлтэй болон давуу талыг нэлээд дэлгэрэнгүй ярьсан бол төгсөгч Мөнхтулга хос мэргэжлээр ШУТИС-ийг төгссөн тухайгаа, мөн солонгос хэлний мэргэжлийн ачаар аялал жуулчлалын компаниа хэрхэн ажиллуулж амжилт гаргаж байгаа тухайгаа ярьж асуултанд хариулж ярилцав.

ТОПИК шалгалтын бэлтгэл хичээл



Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтад өндөр оноо авч тэнцэхийн тулд хичээлийн хөтөлбөрийн дагуу хэлээ судлахаас гадна шалгалтын материалаар дагнаж тактик судлах, тухайн даалгавар бүрийн онцлогийг судалж, мэдлэг чадвараа дээшлүүлэхийн тулд клубийн цагаараа гишүүд маань ТОПИК шалгалтын материалаар хичээллэдэг. Хичээлийн болон клубийн цагаа үр дүнтэй ашиглан сурч чадсанаар 2-р курсдээ ТОПИК 4-р түвшин хангасан Б.Цэлмэг, О.Хүслэн, Г.Мөнхшүр нар бусад оюутнууддаа үлгэр дуурайлал болж сурах идэвх өрнүүлэхэд нөлөө үзүүлсэн юм.

Шинэ элсэгч нарт зориулсан клуб танилцуулах ажиллагаа 2020



Намрын улиралд ШУТИС ГХС-д шинээр элсэн орсон оюутнуудад ГХС-ийн клубүүдийг танилцуулдаг уламжлалын дагуу Солонгос хэлний клубийн зөвлөх багш Т.Мөнхжаргал клубийн танилцуулга хийдэг. Цар тахлын нөхцөл байдлын улмаас уг танилцуулгыг онлайнаар хийж шинэ элсэгчдийг клубээр дамжуулан чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх, их зүйл сурахыг уриалдаг билээ.

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн оюутнуудад зориулсан солонгос хэлний анхан шатны хичээл



Бүрэлдэхүүн сургуулиудын оюутнуудаас солонгос хэлийг судлах хүсэлтэй оюутнууд цөөнгүй байдаг. Тэдний зарим нь манай клубт нэгдэн үнэ төлбөргүйгээр солонгос хэлний мэдлэгтэй болдог. Тэдгээр оюутнуудад зааж байгаа солонгос хэлний оюутнууд ч мөн өөрийн мэдлэгээ батжуулж, бусдад зааж сургах чадвар дадалтай болдог.

Дээд курсийн оюутнууд туршлагаа хуваалцах ажил 2021



Клубийн гишүүд дундаас илүү туршлагатай, илүү сайн суралцаж байгаа оюутнууд бага курсийн дүү нартаа солонгос хэл сурч буй туршлагаа хуваалцдаг уламжлалтай билээ.

Тус клубийн гишүүн Б.Буюанжаргал солонгос хэлний сонсох чадвараа хөгжүүлсэн туршлага, хичээл давтах арга барилаа доод курсийн дүү нартайгаа хуваалцлаа. Богино хугацаанд сонсох, ярих чадвараа хөгжүүлэхийн тулд кино, бичлэгийг тогтмол үзэж мэдэхгүй үг, хэллэг зэргийг анхааран цээжилж, ном зохиол уншдаг туршлагаа ярилаа. Оюутнууд анхааралтай сонсож, маш тааламжтай хүлээж авч байлаа.

Судалгааны ажлаа танилцуулах ажил 2021



Клубийн гишүүдийн дундаас оюутны эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн оюутнууд бусад гишүүддээ судалсан зүйлээ хуваалцдаг. 2-р курсийн оюутан Б.Номин “Солонгос хэлэн дэх хүндэтгэлийн ёс”-ны талаар судалгаа хийснээ танилцуулав. Солонгос хэлний хүндэтгэлийг илэрхийлэх ёс нь эзэн биеийн хувьд, харьцаж байгаа хүний хувьд, үгийн сангийн нэгжүүдээр, хэл зүйн олон хэлбэрээр илэрч байгаа нь монгол хэлнээс ялгаатай онцлог байгааг тэмдэглэн хэлж байлаа. Клубийн бусад гишүүд судалгааны ажлын талаар нэлээд мэдлэг, ойлголт авлаа.

Гадаад оюутантай хийдэг үулзалт 2021




ШУТИС, МУИС зэрэг сургуульд суралцаж байгаа солонгосын солилцооны оюутан, магистрант оюутнуудтай үулзалт зохион байгуулдаг уламжлалтай. БНАСАУ-аас тус улсад ирж магистрантаар суралцаж байгаа И Юү Жин-тэй үулзалт зохион байгуулж манай улстай удаан жилийн найрамдалт харилцаатай явж ирсэн Ардчилсан солонгос улсын талаар нэлээд мэдээлэл авсан юм.

Өмнө нь БНСУ-ын Данкүк их сургуулиас ГХС-ийн монгол хэлний бэлтгэлд ирж суралцаж байгаа оюутнуудтай клубийн үйл ажиллагааны явцад үулзаж танилцан солонгос залуусын дуртай тоглоом наадгайг заалгасан билээ. Мөн Данкүк их сургуулиас ирж суралцахдаа монгол нэртэй болсон Үүрээ, Ану нартай Хангыл үсгийн баярын үеэр Самүлнури цохиур хөгжим хамтран тоглосон юм.

2022 онд солонгос хэлний клубт шинэ элсэгч нар нэгдэн орж, клубийн үйл ажиллагааг үргэлжлүүлсэн бөгөөд клубийн нэрийг “Кассен” буюу “хичээж амьдрах” гэсэн үгээр нэрлэв. Клубийн

ахлагчаар М.Намуун-Эрдэнэ ажиллаж, клубийн гишүүд хамтдаа бийрэн бичлэгт суралцав. Мөн уламжлалт сургалтууд, соёлын арга хэмжээг явуулж байлаа.



Самүлнури цохиур хөгжим заалгав /2022.9 сар/



Солонгосын ардын хөгжим Самүлнури-г тус клубийн хуучин гишүүд, ГХС-ийн төгсөгч О.Хүслэн, Б.Халиун нар 1-р курсийн дүү нартаа зааж өгч хэдэн оройг дуу шуугиантай өнгөрөөв.



Клубийн гишүүд шинэ хичээлийн жилийн нээлтийн ажиллагаанд солонгос үндэсний хувцсаа өмсөж идэвхтэй оролцов. /2022.9 сар/

Клубийн ахлагч Э.Нарангарав солонгос хэлний хичээлийг бусад гишүүдийн дэмжлэгтэйгээр явуулж, салбар сургуулийн оюутнууд идэвхтэй сурдаг. /2023.10/



Манай Кассен клубийн гишүүд хамтарч ажиллах, бусдад зааж сургах, цагийг бүтээлч үр дүнтэй өнгөрөөх дадал чадварыг эзэмшиж, солонгос хэлний үр чадвар, мэдлэгээ сайжруулахын төлөө клубтээ идэвхтэй хамрагдсаар байна.